



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/285

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2024 оны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Нэгдсэн хогийн цэг цэвэрлэх ажилд шаардлагатай хамгаалах хувцас хэрэгслийг Эрүүл мэндийн яамнаас татан авах болсон тул Улаанбаатар хотоос тээвэрлэж ирэх шатахууны зардал 850,000 (Найман зуун тавин мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд зарцуулагдах нийт 850,000 (Найман зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ